



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 1/50

Улаанбаатар хот

### Гадаад албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийх албан ёсны айлчлалын үеэр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус улсын Төрийн зөвлөлийн дэргэдэх Төрийн өмчийн хяналт, зохицуулах хороотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хоёр улсын төрийн өмчит компани, аж ахуйн нэгжийн хоорондын хамтын ажиллагааг тогтоож, туршлага судлах тул “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсөронзон, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Ц.Амарсанаа, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирал Г.Гансүх нарыг 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл гадаад албан томилолтоор ажиллуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд оролцуулахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Д.Дэлгэрмаа, Ц.Түвшинзаяа, Гадаад харилцаа, орон нутаг хариуцсан мэргэжилтэн У.Усгал нарыг мөн өдрөөр гадаад албан томилолтоор ажиллуулсугай.

3. Энэ тушаалын 2-т заасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан тушаалтнуудын гадаад албан томилолтын зардлыг хавсралтад заасны дагуу хариуцан гаргахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсөронзон, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Ц.Амарсанаа, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирал Г.Гансүх нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132013588

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2023 оны 06 дугаар сарын ....-ны  
өдрийн.... дүгээр тушаалын хавсралт

ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

№	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан тушаалтны нэр	Албан тушаал	Зардал хариуцах байгууллага
1	Ц.Баяр-Эрдэнэ	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга	“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ
2	У.Усгал	Гадаад харилцаа, орон нутаг хариуцсан мэргэжилтэн	
3	Д.Дэлгэрмаа	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ
4	Ц.Түвшинзаяа	Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн дарга	“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ

----000----